

2

Дархан Сэлэнгийн Цахилгаан Түгээх Сүлжээ Хувьцаат Компани

Төлөөлөн Удирдах Зөвлөлийн тогтоол

2015 оны 3-р сарын 16-ны өдөр

Дугаар 03/01

Улаанбаатар хот

Компанийн үйл ажиллагааны болон санхүүгийн
тайлангийн талаар дүгнэлт гаргах тухай

Монгол улсын Компанийн тухай хуулийн 76 дугаар зүйлийн 76.1.11, 80 дугаар зүйлийн 80.2 дахь хэсэг, Дархан Сэлэнгийн Цахилгаан Түгээх Сүлжээ хувьцаат компани /цаашид "Компани" гэх/-ийн дүрмийн 7 дугаар зүйлийн 7.32.5 дахь хэсэг болон 7.34 дэх хэсэг, Компанийн Төлөөлөн удирдах зөвлөл /цаашид "ТУЗ" гэх/-ийн 2015 оны 3 дугаар сарын 9-ны өдрийн хурлын тэмдэглэлийг үндэслэн ТОГТООХ нь:

Нэг. Компанийн жилийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайланг хангалттай гэсэн үнэлгээгээр дүгнэсүгэй.

ДАРГА



Ц.ЦЭНГЭЛ

Дархан Сэлэнгийн Цахилгаан Түгээх Сүлжээ Хувьцаат Компани

Төлөөлөн Удирдах Зөвлөлийн тогтоол

2015 оны 3-р сарын 16-ны өдөр

Дугаар 03/02

Улаанбаатар хот

Компанийн бизнес төлөвлөгөө, төсвийг батлах тухай

Монгол улсын Компанийн тухай хуулийн 80 дугаар зүйлийн 80.2 дахь хэсэг, Дархан Сэлэнгийн Цахилгаан Түгээх Сүлжээ хувьцаат компани /цаашид "Компани" гэх/-ийн дүрмийн 7 дугаар зүйлийн 7.32.2 дахь хэсэг болон 7.34 дэх хэсэг, Компанийн Төлөөлөн удирдах зөвлөл /цаашид "ТУЗ" гэх/-ийн 2015 оны 3 дугаар сарын 9-ны өдрийн хурлын тэмдэглэлийг үндэслэн **ТОГТООХ** нь:

Нэг. Компанийн 2015 оны бизнес төлөвлөгөө, төсвийг энэхүү тогтоолын Хавсралт 1-ийн дагуу баталсугай.

Хоёр. Энэхүү тогтоолын хэрэгжилтийг хангаж ажиллахыг Гүйцэтгэх захирал /С.Нэргүй/-д даалгасугай.

ДАРГА



Ц.ЦЭНГЭЛ

Дархан Сэлэнгийн Цахилгаан Түгээх Сүлжээ Хувьцаат Компани

Төлөөлөн Удирдах Зөвлөлийн тогтоол

2015 оны 3-р сарын 16-ны өдөр

Дугаар 03/03

Улаанбаатар хот

Ногдол ашиг хувиарлах эсэх тухай

Монгол улсын Компанийн тухай хуулийн 76 дугаар зүйлийн 76.1.12, 80 дугаар зүйлийн 80.2 дахь хэсэг, Дархан Сэлэнгийн Цахилгаан Түгээх Сүлжээ хувьцаат компани /цаашид "Компани" гэх/-ийн дүрмийн 7 дугаар зүйлийн 7.32.5 дахь хэсэг болон 7.34 дэх хэсэг, Компанийн Төлөөлөн удирдах зөвлөл /цаашид "ТУЗ" гэх/-ийн 2015 оны 3 дугаар сарын 9-ны өдрийн хурлын тэмдэглэлийг үндэслэн ТОГТООХ нь:

Нэг. Компанийн ТУЗ-ийн Аудитын хорооны дүгнэлтийг үндэслэн Компанийн нийт энгийн хувьцаа эзэмшигчдэд 2014 оны үйл ажиллагаагаар ногдол ашиг олгохгүй байхаар тогтоосугай.

Хоёр. Компанийн ТУЗ-ийн Аудитын хорооны дүгнэлтийг Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд танилцуулах үүргийг Компанийн ТУЗ-ийн Аудитын хорооны дарга /Л.Балган/-д үүрэг болгосугай.

ДАРГА



Ц.ЦЭНГЭЛ

Дархан Сэлэнгийн Цахилгаан Түгээх Сүлжээ Хувьцаат Компани

Төлөөлөн Удирдах Зөвлөлийн тогтоол

2015 оны 3-р сарын 16-ны өдөр

Дугаар 03/04

Улаанбаатар хот

Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг зарлан хуралдуулах тухай

Монгол улсын Компанийн тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.2, 80 дугаар зүйлийн 80.2 дахь хэсэг, Дархан Сэлэнгийн Цахилгаан Түгээх Сүлжээ хувьцаат компани /цаашид "Компани" гэх/-ийн дүрмийн 7 дугаар зүйлийн 7.32.5 дахь хэсэг болон 7.34 дэх хэсэг, Компанийн Төлөөлөн удирдах зөвлөл /цаашид "ТУЗ" гэх/-ийн 2015 оны 3 дугаар сарын 9-ны өдрийн хурлын тэмдэглэлийг үндэслэн ТОГТООХ нь:

Нэг. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал (цаашид "Хурал" гэх)-ыг 2015 оны 4 дүгээр сарын 30 -ны өдрийн 15 цагт "Хасвуу" плазагийн хурлын танхимд хуралдуулсугай.

Хоёр. Хурлаар дараах асуудлыг хэлэлцсүгэй: (i) компанийн санхүүгийн тайлан болон түүнд хийгдсэн хараат бус аудитын дүгнэлтийн талаарх ТУЗ -ийн дүгнэлт бүхий тайланг батлах, (iii) компанийн ногдол ашгийн талаар гаргасан ТУЗ-ийн шийдвэрийг хэлэлцэх, (iv) компанийн ТУЗ-ийн ердийн болон хараат бус гишүүдийг сонгох, (v) Компанийн ТУЗ-ийн гишүүдийн 2015 оны цалин урамшуулал болон зардлыг батлах, (vi) бусад.

Гурав. Хуралд оролцох эрхтэй хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалт гаргах бүртгэлийн өдрийг 2015 оны 3-р сарын 31-ны өдрөөр тогтоосугай.

Дөрөв. Хурал хуралдуулах тухай хувьцаа эзэмшигчдэд мэдэгдэх өдрийг 2015 оны 3-р сарын 20-ны өдрөөр тогтоон, Санхүүгийн зохицуулах хорооны 2012 оны 34 дүгээр тогтоолын хавсралтаар баталсан Хувьцаат компанийн хувьцаа эзэмшигчдийн хурлын зар хүргэх журамд нийцүүлэн хувьцаа эзэмшигчдэд мэдэгдсүгэй.

Тав. Хувьцаа эзэмшигчид нь компанийн 2015 оны санхүүгийн тайлан тэнцэл болон, компанийн 2014 оны бизнес төлөвлөгөө, Хувьцаа эзэмшигчдийн хурлын тогтоолын төсөл зэрэгтэй танилцаж болно.

Зургаа. Хурлын даргаар Ц.Цэнгэлийг томилсугай. Тооллогын комиссын даргаар ТУЗ-ийн хараат бус гишүүн Л.Балган, гишүүдээр ТУЗ-ийн гишүүн Э.Долгорсүрэн, ТУЗ-ийн нарийн бичгийн дарга М.Баярманла нарыг тус тус томилсугай.

Долоо. Саналын хуудасын агуулгыг хавсралт ёсоор батлан, саналын хуудсыг авах сүүлчийн өдрийг 2014 оны 4 дүгээр сарын 30-ны өдрөөр тогтоосугай.



Ц.ЦЭНГЭЛ